



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОЛОВСРОЛ: ЁС СУРТАХУУНЫ БОЛОН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭГЭЭ

Abstract

In this article focused on some ideas and tendencies of education of sustainable development, these are related to justification of ethic and science, through philosophy-theory.

Нийгэм, эдийн засаг, экологийн асуудлын шийдвэрт хүн бүрийн оролцох бололцоог хангахуйц боловсрол олгох зорилт дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгамдсан зорилго болж байна. Энэ зорилго 1992 онд Бразилийн Рио-Де-Жанейро-д болсон дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтын үндсэн сэдэв байж, тэндээс иргэншлийн шинэ загвар болох "Хөгжлийн хөтөлбөр- 21" баримт бичгийг баталснаар тогтвортой хөгжлийн тухай үзэл баримтлал түгэн дэлгэрсэн билээ. Эдүгээ олон орон "Хөгжлийн хөтөлбөр- 21" буюу тогтвортой хөгжлийн хөтөлбөрөө боловсруулан хэрэгжүүлж эхлээд байгаа билээ. Монгол улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүн болохынхоо хувьд Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг Үндэсний, бүс нутгийн хэмжээнд боловсруулан хэрэгжүүлж байна.

Хөгжлийн хөтөлбөрт тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх арга хэрэгслийг боловсрол хэмээн тодорхойлсон байдаг. Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалын үндэс "Монгол улсын бүх нийтийн экологийн боловсролын үндэсний хөтөлбөрт" туссан бөгөөд судлаачдын тэмдэглэж байгаагаар¹ Монгол улсад тогтвортой хөгжлийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр төрөөс баримтлах цэгцтэй бодлого, үр өгөөжтэй үйл ажиллагаа зэрэг нь бүхэлдээ эхлэлийн шатандаа явж байна гэж үзэж болохоор юм. Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санаа, чиг хандлагыг тайлбарлах, сурталчлах, өөрийн улсын боловсролын бодлогод тусган бодитой үйл ажиллагаа болгоход чиглэсэн судалгаа шинжилгээний болон аргагүйн шинжтэй өгүүлэл, ном товхимлууд ч цөөнгүй гарч эхлээд байгаа билээ.

Ингээд тогтвортой хөгжлийн боловсролын шинжлэх ухааны болон ёс суртахууны үндэслэгээнд хамаарах

¹ Тогтвортой хөгжлийн боловсрол. УБ. 2008. 47 дэх тал.



МУБИС-ийн ТНУС-ийн
Философи, дидактикийн
тэнхимийн багш, доктор
(Ph. D.) Т.Нэмэхжаргал

зарим асуудлыг философи-онолын үүднээс эргэцүүлэх зорилго тавин энэхүү өгүүлийг толилуулж байна.

Тогтвортой хөгжлийн боловсролын ёс суртахууны үндэслэгээ. Юуны түрүүнд, соёл иргэншлийн хөгжил, дэвшлээс үүдэн байгаль, экологийн тэнцвэр алдагдаж буйгийн учир шалтгаан нь соёл, шинжлэх ухааны ололт амжилтыг ашиглах ёс суртахууны хэм хэмжээ бүхий л түвшинд үгүйсгэгдэж байгаатай холбоотой. Тодруулбал, хүмүүний ёс суртахуун бүтээсэн соёлоосоо хоцорч, ёс суртахуун өнөөгийн байгаа байдлаараа экосистемийн асуудлыг шийдвэрлэх чадваргүй болжээ гэсэн үг юм.

Боловсролыг хүн төлөвших үйл явц гэсэн өргөн утгаар авч үзэж, шинжлэх ухааны мэдлэгийг өөриймшүүлэн ололт амжилтыг нь хэрэглэх, ашиглах, түгээх ёс суртахууны хариуцлагатай иргэн төлөвшүүлэх шаардлагатай цаг үед бид иржээ. Тогтвортой хөгжлийн боловсролын хүрээнд яригдаж буй ёсгүй бол ёсгүйг зөвхөн хүмүүсийн хоорондын харилцааны асуудал гэж ойлгодог уламжлалт үзэл төсөөлөл, мөн түүнчлэн, өнөөгийн нийгэмд зонхилох болсон

хэрэглээ баримжаатай ёс суртахуунаас хавьгүй өргөн хүрээтэй асуудал гэдгийг онцлох нь зүйтэй. Учир нь тогтвортой хөгжлийг гагцхүү боловсролтой холбон үзэж байгааг явцуу утгаар нь авч үзвэл, бидний амьдарч буй шинэ эрин үед шаардагдах ёсгүйн хэм хэмжээг багш, мэргэжилтнүүдийн тусламжтайгаар түгээн дэлгэрүүлж, төлөвшүүлэх асуудал, харин энэхүү үйл ажиллагааны хүрэх үр дүн нь нийгэм-соёлын аливаа үзэгдэл үйл явцын учирзүйг ойлгох чадвар бүхий үнэлэмжийн баримжаатай, нийгмийн аливаа үйл ажиллагааг эрхлэхүйц соёл, ёс суртахууны зарчим, хэм хэмжээг өөриймшүүлсэн бүтээлч хүний хөгжин төлөвших үйл явц мөн гэж тус тус тодорхойлж болох юм.

Яагаад ёс суртахууны хэм хэмжээг чухамхүү багш, мэргэжилтнүүд зориудаар түгээн дэлгэрүүлэх шаардлагатай болов? хэмээн асууж болох юм. Учир нь хүн төрөлхтний түүхийн өмнөх үеүдэд гарч байсан өөрчлөлт, дэвшилүүд энэхүү өөрчлөлт, дэвшилдээ зохицсон ёсгүйн хэм хэмжээг боловсорч, төлөвшихэд хангалттай цаг хугацааг хүмүүст олгож байжээ. Иймээс уламжлалт ёсгүй нь нийгмийн шаардлагад нийцсэн зохистой харьцааг хадгалах, зохицуулах үүргээ гүйцэтгэсээр ирсэн байна. Гэтэл орчин үеийн нийгмийн хөгжил, өөрчлөлтийн хурд нь тухайн өөрчлөлтөндөө нийцсэн ёсгүйн хэм хэмжээг боловсорч, төлөвшихүйц хэмжээний цаг хугацааг олгох боломжгүй болжээ. Ийм байдлын нэг илрэлийг, тухайлбал, ёс суртахуун өнөө үед хүмүүсийн хоорондын харилцаанаас илүү хэрэглээг нь үнэлэх үүргийг гол төлөв гүйцэтгэх болсон явдал гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан, техникийн ололт амжилтыг байж болох бүхий л талаар ашиглаж, хэрэглэж байгаа, энэ утгаараа хөрөнгө чинээтэй, хөгжингүй гэгддэг бүхнийг ёсгүйтэй гэж дүгнэхэд хүрч байна.

Ёс суртахууныг хэмжих шалгуурыг өндөр хэрэглээ, техник гэж үзэх бус, харин ёс суртахуунаар тэрхүү хэрэглээг хэмжих, соёл, шинжлэх ухаан, техникийн ололт амжилтыг ашиглахад ёс суртахууныг гол шалгуур болгох хэрэгцээ шаардлага бий болжээ.



Тогтвортой хөгжлийн хамгийн наад захын шаардлага, тухайлбал, аль ч түвшинд /дэлхийн, бүс нутгийн, улс орны, орон нутгийн, гэр бүл, хувь хүний/ үрэлгэн хэрэглээнээсээ татгалзах, хог хаягдлыг багасгах улмаар аж төрөх арга ухаан, хэв маягаа өөрчлөх гэх мэт асуудал нь яах аргагүй ёсзүйн асуудалд хүргэх билээ. Тогтвортой хөгжлийн боловсролын алс хэтийн зорилго бол хэрэглээнд суурилсан өнөөгийн нийгмээс хүмүүнлэг ёс суртахуун, бүтээлч байдал, хамтын ойлголцол, мэргэжлийн чадвар, чанар гэх мэт үнэлэмжид тулгуурласан нийгэмд шилжих үйл явц мөн.

Ёсзүй бол өөрийн зарчим, категориудтай, философийн нэг салбар ухаан билээ. Тогтвортой хөгжлийг хангахуйц боловсролд ёсзүйн үндсэн ойлголт, зарчмуудад тулгуурласан ёсзүйн ухааны харьцангуй шинэ чиглэлүүд болох мэргэжлийн ёсзүй, биоэтик, техноэтик чухал үүрэгтэй гэж үзэж байна.

Мэргэжил бүхэн тодорхой шинжлэх ухааны төлөөлөл байдаг бөгөөд мэргэжлийн ёсзүй бол тухайн мэргэжлийн хүмүүнлэг утга холбогдлыг гол шалгуур болгон нийт хүн төрөлхтний шинжтэй ёс суртахууны зарчмуудыг тухайн мэргэжлийн үйл ажиллагаанд нийцүүлэх зорилготой байдаг. Биоэтик бол аливаа амьд биетийг үнэт чанар гэдэг талаас нь авч үзэж, хүн төрөлхтөн бол байгалийн нэг хэсэг, амьдрал бол үнэт зүйл гэсэн зарчимд тулгуурладаг. Харин техноэтик бол шинжлэх ухаан, техникийн ололт амжилтыг ашиглахад ёс суртахууны хэм хэмжээг гол шалгуур болгох зарчимд тулгуурладаг. Энд өгүүлэн буй ёсзүйн чиглэлүүд хүн болон хүрээлэн буй орчны төлөө хариуцлага төдийгүй, ирээдүйн төлөө, өөрсдийн оршихуйн эх үндсийг бидний нэг адил байгаль орчин гэж үзэх эрх бүхий хойч үеийн төлөө хүлээх хариуцлагын ёсзүй мөн.

Тогтвортой хөгжлийн боловсролын шинжлэх ухааны үндэслэгээ. Хөгжлийн хөтөлбөрт тогтвортой хөгжлийн бүрдэл хэсгүүдэд эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжил, хүрээлэн байгаа орчны хамгаалал гэсэн гурван хүчин зүйлийг авч үздэг бөгөөд энэхүү бүрдэл хэсгүүдийг интеграцчилах, энэ чиглэлд олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх нь тогтвортой хөгжлийн үндэс болох тухай заасан байдаг. Тэгвэл эдийн засгийн хөгжил, нийгмийн хөгжил, хүрээлэн байгаа орчин дээр гурван хүчин зүйлийнхээ онцлогийг судалгааны объект болох талаас нь авч үзье.

Эдийн засаг, нийгмийн хөгжлийг судалдаг шинжлэх ухаан буюу нийгмийн ухааны мэдлэг, онол нь нийгмийн үзэгдэл, үйл явцыг судалж, ойлгосны үндсэн дээр судлаачдын хийсэн тайлбар, дүгнэлт, шийдвэр хэлбэртэй байдаг. Харин байгалийн үзэгдэл юмсыг судалдаг байгалийн шинжлэх ухааны мэдлэг бол угтаа байгальд өөрт нь агуулагддаг хууль, зүй тогтлуудыг судлаач танин мэдсэний үндсэн дээр нээж илрүүлсний үр дүн байдаг билээ. Иймээс нийгэм, эдийн засгийн онол, дүгнэлтийг хүмүүс зохиодог, тодорхой нөхцөл байдалд хэрэглэж болдог, бас нөхцөл байдлаас хамаарч өөрчилж болдог. Харин байгалийн хууль нь практикаар батлагддаг, нөхцөл байдлыг дагаж өөрчлөгддөггүй, харьцангуй тогтвортой шинжтэй юм.

Байгалийн хуульд хүмүүс суралцаж, байгалийн оршихуй болохынхоо хувьд түүнд нийцүүлэн бодлогоо тодорхойлох учиртай аж. Тэгэхээр байгаль-нийгмийн тогтолцоо бүхэлдээ хямралд орсныг нийгмийн бодлого, онол, шийдвэр нь байгалийн хуульд нийцэхгүй байгаагийн үр хөврөл гэж үзэх бүрэн үндэстэй. Энэхүү үл нийцлээс гарах арга зам буюу байгаль, нийгэм, эдийн засгийн асуудлыг багтаасан дэлхий нийтийн шинжтэй цогц арга хэмжээ бол "тогтвортой хөгжлийн" үзэл баримтлал юм. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг шинжлэх ухааны судалгааны үндсэн парадигм хэмээн тодорхойлж байгаа нь уг үзэл санааны нэн тулгамдсан шинжтэй гэдгийг давхар илтгэжбайгаа юм. Парадигм гэж юу вэ?

Парадигм хэмээх ойлголт грек хэлний *paradigma* - үлгэр, загвар гэсэн утгатай. 1970 - гаад онд шинжлэх ухааны философид хэрэглэгдэх болсон энэ ойлголт нь, нэгдүгээрт, тухайн шинжлэх ухааны нийгэмлэгийн хувьд хүчин төгөлдөр үйлчилж байдаг итгэл үнэмшил, үнэлэмж, техник арга хэрэгслүүдийн бүхийл нийлбэр цогц гэсэн утгыг илтгэдэг, хоёрдугаарт, ухаан сорьсон асуудлуудын шийдвэр бологч нэг элементийг илэрхийлэх бөгөөд энэхүү элемент нь дээр яригдсан итгэл үнэмшил, арга хэрэгслүүдийн нийлбэр цогцод байна² гэсэн санааг илэрхийлдэг.

Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл баримтлалыг парадигм мөн гэж үзвэл мөн л дээр дурдсан хоёр утгыг илэрхийлж байна. Тухайлбал, нэгдүгээрт, бидний амьдарч буй эрин үеийн судлаач, эрдэмтдийн судалгааны үндсэн зарчим, чиг баримжаа нь

² Т.Кун. Структура научных революции. М.,1977. С.228

тогтвортой хөгжлийн үзэл баримтлал байна, хоёрдугаарт, орчин үеийн ээдрээтэй олон асуудлыг шийдвэрлэх замаар тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх гол элемент нь боловсрол байна гэдгийг тус тус тодорхой болгож байна. Энэ нь тогтвортой хөгжлийг хөгжлийн үндэс суурь хэмээн үзсэнээр аливаа шинжлэх ухааны судалгааг "боловсрол ба нийгэм экосистемийн" асуудалд чиглүүлэх асуудал мөн.

Тогтвортой хөгжлийн боловсролын ёс суртахууны болон шинжлэх ухааны үндэслэгээг ийнхүү эргэцүүлсний дүнд дараах саналыг хэлж болохоор байна. **Үүнд:** хүүхэд, залуус амьдралынхаа бүхэл бүтэн үеийг зарцуулдаг хичээл, сургалтыг тогтвортой хөгжлийн эзэд хөгжиж, төлөвшиж байдаг бүтээлч орчин гэж ойлгон багш бид заадаг шинжлэх ухааныхаа хүмүүнлэг үнэ цэнд нь тулгуурлан хөтөлбөртөө өөрчлөлт хийх, нөгөө талаас, тогтвортой хөгжлийн үзэл санаа нь хүн төлөвшлийн асуудалд хариуцлагын ёсзүйн үзүүлэлтийг урьд өмнө хэзээ ч байгаагүй тийм чухал байр сууринд тавьж өгч байгаагаараа шинжлэх ухааны судалгааны харьцангуй шинэлэг гэж болох олон арван чиглэлийг, тухайлбал, экологи ба хөгжил, хүний хөгжлийн тэгш байдал, мэргэжлийн ёсзүй, биоэтик, техноэтик, өнөө үеийн сэтгэлгээний хэв шинж, арга барил, хандлагын өөрчлөлт гэх мэт чиглэлүүдэд багш-боловсролын судалгааг хандуулах хэрэгтэй болов уу.

НОМЗҮЙ

- Тогтвортой хөгжлийн боловсрол. Уб.,2008.
- Монгол улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр. Уб.,1999
- Войтыла К. «Основания этики», Вопросы философии, 1991., №1.
- Канке.В.А. Философия. М.,2001
- Кун.Т. Структура научных революции. М.,1977